

АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

2023.09.29

Баянтал сум

№	Үүрэг даалгавар	Биелэлт	
1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдаагүй албан хаагчдаа хамруулах	100	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоонд дараах байгууллагууд хамрагдсан. Үүнд: ЗДТГазар нийт 18 ажилтнаас 17 хамрагдсан, Сургууль нийт 26 ажилтнаас 21 хамрагдсан, Цэцэрлэг нийт 12 ажилтнаас 12 хамрагдсан, Соёлын төв нийт 5 ажилтнаас 5 хамрагдсан, Эрүүл мэндийн газар нийт 14 ажилтнаас 4 хамрагдсан, Талын илч ОНӨААТҮГазар нийт 24 ажилтнаас 24 тус тус хамрагдсан. Эрт илрүүлэг оношилгоонд хамрагдаж амжаагүй албан хаагчдыг 2023 онд багтаан 100% хамруулна.
2	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх	100	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/90 тоот захирамж гарч ажлын хэсэг томилогдсон. Ажлын хэсэг сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага, айл өрхүүдээр орж өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах талаар үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажилласан. Талын Илч ОНӨААТҮГазар нь сумын төвийн гадна болон дотор шугам, орон сууцнуудын сантехникийн шугам хоолой, халаалтын зуух зэрэг инженерийн шугам сүлжээний засвар арчлалтын ажлыг бүрэн хийж дуусгасан. Сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.

3	Багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж, хариуцлагжуулж ажлын үр дүнг тооцож улирал тутамд танилцуулж ажиллах, амралтыг дуусгаж ажилд нь оруулах	100	Сумын 1-р багийн Засаг дарга ээлжийн амралтаа дуусгаж ажилдаа орсон. 2023 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг бэлтгэл ажлыг хангуулахаар Багийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Сумын хэмжээнд цэргийн алба хаагаагүй, цэрэгт татагдах 18-26 насны иргэдийн судалгааг гаргаж аймгийн цэргийн штабт хүргүүлсэн. Цэргийн зарлан дуудах хуудсыг тарааж хүргүүлэхээр багийн Засаг дарга нарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна.
4	Малын угаалгатай холбоотой судалгаа, мэдээллийг Цагдаагийн хэлтэст хүргүүлэн танилцуулах	100	“ХИЛИЙН ДЭЛГЭРЭХ” ХХК-н Мал эмнэлэгт 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 23,000 толгой бог малд угаалга хийсэн. Үүнд: 12,000 ямаа 11,000 хонь угаалга хийсэн байна. Аймгийн Мал эмнэлэгийн газраас “ХИЛИЙН ДЭЛГЭРЭХ” ХХК-д 110 литр мал ариутгалын бодисийг хүлээлгэж өгсөн. Үүнээс: 50 литрийг мал ариутгалд хэрэглэж, 60 литрийг аймгийн Мал эмнэлэгийн газарт буцаан хүлээлгэж өгсөн байна.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

СУМЫН ЗДТГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ц.ЛХАГВАДОНИД

Б.ГАНБАЯР

